

## ЛУУС СУМЫН ИТХ-ЫН ДАРГААР АЖИЛЛАЖ БАЙСАН ХҮМҮҮСИЙН ТУХАЙ, ДУРСАМЖААС ...

Сумын анхны ИТХ-ын дарга Б.Батмөнх 1992-1994 оны ИТХ-ын дарга



**Эцэг, эхийн нэр:** Бат-Очир

Нэр: Батмөнх

Төрсөн газар: Дундговь аймгийн Буянт сум буюу одоогийн Өлзийт сум

Боловсрол: Дээд

Мэргэжил: Улс төр

Төгссөн сургууль: Намын дээд сургууль

**Урьд болон одоо ажиллаж байгаа газар:** 1956 оноос Буянт овоо сумандаа захиргааны нарийн бичгийн даргаар ажлын гараагаа эхлэж сумын депутатаар 8, аймгийн депутатаар 5, улсын их хурын депутатаар 1 удаа сонгогдож Өндөршил, Говь- Угтаал, Луус сумдад сумын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга, сум нэгдлийн даргаар 22 жил ажиллаад өндөр насны тэтгэвэртээ гарсан.

**ИТХ-ын байгууллагат ажилласан түүхэн дурсамж, онцлог үйл явдлаас:**

1992 он монгол улс - улс төр, нийгэм, эдийн засгийн социалист тогтолцоог халж эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэмд шилжих хувьсгалт эргэлтийн жил байж түүхэн ач холбогдол бүхий үйл явдлууд логик дэс дарааллаар өрнөсөн жил байлаа.

Тухайлбал:

Ардчилсан шинэ үндсэн хууль батлагдан мөрдөгдөж, улсын их хурал, засгийн газар, шүүх засаглал байгуулагдаж, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудыг байгуулах сонгууль томилолт болж өмчийн олон хэлбэрт зах зээлийн харилцаанд эргэлт буцалтгүй шилжсэн юм.

Энэхүү түүхэн шинэчлэл өөрчлөлт эхэлсэнээр 25 жил болж Монгол улс ардчилсан ёс тогтоох хийгээд хэрэгжүүлэх талаар дэлхий даяар үлгэр жишээ орны тоонд багтан яригдах болсон нь Монголын бахархал, Монгол улсын шинэ үндсэн хуулийн мөнхийн гавъяа юм.

Үндсэн хуулийнхаа ач холбогдлыг бишрэн судлаж мэдэж, хэлбэрэлтгүй сахин мөрдсөний 25 жилийн ойг улс даяараа хүндэтгэлтэйгээр тэмдэглэж байгаагийн зэрэгцээ Монгол улсын нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаа байгуулсны 25 жилийн ойг дурсамж дурдатгал, ололт амжилт сургамжийг нэгтгэн дүгнэж баг, сум, аймаг, хотоороо хүндэтгэн тэмдэглэж байна.

Их ойнуудыг тэмдэглэх бүрт иргэд өөрийн оролцоо, байр сууриа ой санамжнаасаа шүүн сэргээж санаж, түүнээ хойд үедээ уламжлуулан үлдээдэг жишиг тогтож буй нь энэрэнгүй нийгмийн иргэддээ олгосон өгөөж, давуу тал юм.

Монгол улсын шинэ үндсэн хуулийг хэлэлцэн батлахад Луус сумын 1300 гаруй иргэдийг төлөөлөн оролцож нутгийн өөрөө удирдах байгууллагыг байгуулалцаж ажлыг нь эхлүүлж явсан бидний үеийнхэнд дурсан ярих, бичих зүйл нэн ихийн дотроос товчхон өгүүлвээс:

1992 онд улсын их хурал, аймаг сумын иргэдийн хурлын төлөөлөгч, гишүүдийг сонгох сонгууль болж нутгийн өөрөө удирдах байгууллагуудыг байгуулж ажиллуулсан нь шинэ түүхэн ажил байсан юм.

Төр нийгмийн аливаа ажилд манлайлагч Луус сумынхан ч ямар нэг алдаа завхралгүй жин тан амжуулсан.

Үндсэн хууль байгуулагдмагц орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай, сонгуулийн тухай хуулиуд гарч тэдгээрийг иргэдэд тайлбарлан ойлгуулах, биелэлтийг гардан зохион байгуулагч нарт заавар сургалт явуулах, сонгуульд өрсөлдөгчдийн нэрийг дэвшүүлж мөрийн хөтөлбөрийг боловсруулж танилцуулах ажлууд шил шилээ даран явагдаж, төр захиргааны ажилтнууд туршлага дутагдаж тулгамдаж байсан ч амжилттай зохион байгуулсан..

Аймаг сумын иргэдийн хурлын төлөөлөгчдийн сонгуульд манай Луус сумын сонгогчдын 98 хувь нь саналаа өгч, аймгийн иргэдийн хурлын төлөөлөгчөөр Д.Дэлгэрцогт, Д.Доржпүрэв үнэмлэхүй олны саналаар сонгогдож, бид нийт 21 хүн сумын иргэдийн хурлын төлөөлөгчөөр сонгогдож анхдугаар хурлаа хийж иргэдийн хурлын орон тооны бус даргаар би сонгогдож Луус сумын түүхэнд анхдагчаар бичигдсэн юм.

Энэ албан тушаал нь цоо шинэ, нутгийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлдэг сумын АДХ-ын залгамж боловч илүү ардач бодлого, шийдвэр, биелэлт нь жинхэлсэн эзэнтэй, нутаг ус, хүндээ өгөөжтэй өргөн утгаараа хөгжил дэвшил сайхан бүхнийг сумынхан өөрсдөө гардан буй болгох их ажлын гараа болсон юм.

Ийм их ирээдүй дагуулсан ажилд тохоогдож хурлын төлөөлөгчдийн товч анкет бүхий нэрсийн жагсаалт, анхдугаар хурлын тэмдэглэл дарга тэргүүлэгчдийг сонгож баталсан тогтоолыг тус бүрт нь хавтсанд эмхлэн хийснээр Луус сумын ИТХ-ын ажлыг эхлүүлсэн юм. Тухайн үедээ шинэхэн хуулийг эс тооцвол ажиллах журам заавар гарын авлага байгаагүй ч мэдэн будилж шинэ ажлын ач холбогдол, нэр хүндийг унагаалгүй зорилтод хэмжээнд нь хүргэж ажиллахыг чармайн хэд хэдэн ажлуудыг эхлүүлж байлаа.

- Сумын газар нутаг хүн амын байршлыг харгалзан суврага, зүлэгтийн наран, цагаан овоо (сумын төвийн) гэсэн 4 багт айл өрхөө хуваарьдан багийн иргэдийн хурлууд хийж, багийн иргэдийн хурлын тэргүүлэгчид даргыг сонгон эмхлэн зохион байгуулж доошоо харьцаж тулах хүчнээ буй болгов.
- Сумын иргэдийн хурлын ажиллах журам боловсруулан тэргүүлэгчид, сумын төвийн иргэдэд танилцуулан саналыг авч нэгтгэн тусгаад иргэдийн хурлын гишүүдийн хуралд оруулан хэлэлцүүлж батлаж авснаар ажлаа явуулах удирдамж, гарын авлагатайгаар ажилласан юм.
- Сумын хурал ажлаа жилээр төлөвлөн улирал сарын хувиартай хийж, хугацаанд нь дүгнэж байх.
- Сумын иргэдийн хурлыг улирал тутам, багийн иргэдийн нийтийн хурлыг сар бүр тогтмол хийж байх, улсын албан байгууллага, багийн дарга, удирдах хариуцлагатны шуурхай зөвөлгөөнийг сар бүрийн эхний 7 хоногт хийж ажилдаа үнэлэлт дүгнэлт өгч, хийх ажлаа товлох.
- Сумын иргэдийн хурлын тэргүүлэгчдийн хурлаар засаг дарга, түүний тамгын газрын ажилтан, албан газар, багийн дарга нарын ажлыг сонсон хэлэлцэж чиглэл заалт өгөх, ажлыг нь шалган үнэлэлт өгч сайныг урамшуулж, саарыг засч сайжруулах чиглэл зааварчлага өгөх зэргээр дээрх журманд зааснаар хурлын ажил эхлэж зарим үр дүн гарч байлаа.

Ингэж ажиллах явцад Б.Батмөнх захиргаадалтын үеийн аргаар ажиллаж байна гэсэн шүүмж зэмлэл ч гардаг байлаа.

Тэгэхдээ үнэн чанартаа төр засгийн ажлын залгамж чанарыг агуулсан, иргэд олон түмэнтэй байнгын холбоотой, тэднийг сонсож алсын ажил хэрэгч бүтээлч ажиллахад шинэ байгуулагдсан хурлын ажлын зөв гараа байсан болов уу.

Цэргээс халагдаж төрөлх Буянт овоо сумандаа захиргааны нарийн бичгийн даргаар ажлын гараагаа эхлэж сумын депутатаар 8, аймгийн депутатаар 5, улсын их хурын депутатаар 1 удаа сонгогдож Өндөршил, Говь- Угтаал, Луус сумдад сумын АДХ-ын гүйцэтгэх захиргааны даргаар 22 жил ажилласан минь нутгийн

өөрөө удирдах ёсыг шинэчлэн тогтоож хэрэгжүүлэх их ажлыг гардан зохион байгуулах боломж, давуу тал байсныг тэмдэглэе.

Шагнал:

- Сүхбаатарын одон
- Алтан гадас одон
- Хөдөлмөрийн хүндэт медаль
- Их Монгол Улс байгуулагдсны 800 жилийн ойн медаль
- Ардын хувьсгалын 40,50,60,70,80,90жилийн ойн медалуудыг хүртсэн.

### **ДОВЧИНГИЙН ЧИМЭДЦЭЭЭ 1996-2000 ОНЫ ИТХ-ЫН ДАРГА**



Довчингийн Чимэдцэээ

**Эцэг, эхийн нэр:** Довчин

Нэр: Чимэдцэээ

Төрсөн газар: 1945 онд Дундговь аймгийн Луус сум

Боловсрол: Дээд

Мэргэжил: Хүний их эмч

**Урьд болон одоо ажиллаж байгаа газар:** Сумын орон нутгийн депутатаар 2 удаа, Иргэдийн хурлын төлөөлөгчөөр 2 удаа сонгогдож байсан. 1994 оноос сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн даргаар, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын анхны орон тооны даргаар сонгогдон ажиллаж байсан.

**ИТХ-ын байгууллагат ажилласан түүхэн дурсамж, онцлог үйл явдлаас:**

Ажиллах хугацаандаа нутгийн өөрөө удирдах ёсыг орон нутагт төлөвшүүлэн хөгжүүлэхэд идэвхи зүтгэлтэй ажиллан Иргэдийн хурлын дотоод ажлыг цэгцлэн сайжруулж тэргүүлэгчдийн хурал, төлөөлөгчдийн хурлыг тогтмол хийж, төлөөлөгчдийн ажлыг цуваагаар дүгнэн мэдээлэх, шийдвэр гаргахад иргэдийн оролцоог дээшлүүлж, энэ ажил төрийн хэвлэлд нийтлэгдэн туршлага болж байсан.

Мөн сумын хэмжээний хэд хэдэн болзол гаргаж, “ сумын сайн малчин” “ тэргүүний эмэгтэй”-г шалгаруулан дүгнэж байв. Сумын иргэдэд хандан “ Өрхийн тэргүүний эрхэмлэх 9 зүйл” , “ эмэгтэйчүүд, залуучуудад хүргэх үг” “ найрын дэг” гэх мэт захидлуудыг өрх гэр бүлд хүргэж байсан байна.

Сумаа эрчим хүчний нэгдсэн системд холбогдох ажлыг шаргуу хөөцөлдөн УИХ-ын гишүүн Тогтохын туслалцаатайгаар сумдаас хамгийн түрүүнд сумаа 24 цагийн гэрэл цахилгаантай болгож байсан.

Сумын түмэн адууны баяр, сумын 70 жилийн ой зэргийг тэмдэглэж байсан.

Сумын цагаатгалын комиссын ажлаар 20 гаруй хүний нөхөн олговрын хөөцөлдөн олгуулсан.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын өрөөг анх удаа бий болгон тохижуулан аймагт дотоод ажлаараа 2 удаа 2, 3-р байр эзлэж байсан.

### **ДОРЖСҮРЭНГИЙН САМПИЛ 2004-2012 ОНУУДАД ИТХ-ЫН ДАРГА**



**Эцэг, эхийн нэр:** Доржсүрэн

Нэр: Сампил

Төрсөн газар: 1955 онд Дундговь аймгийн Луус сум Улаан хад

Боловсрол: Дээд

Мэргэжил: Төрийн захиргаа удирдлагын менежер, нягтлан бодогч

1963-1971 онд Луус сумын бага сургууль, Дундговь аймгийн төвийн 10 жилийн сургууль төгсөж 1971 оноос сумын АДХ-ын гүйцэтгэх захиргааны бичээч, бичиг хэргийн эрхлэгчээр ажлын гараагаа эхлэсэн юм. 1980 оноос Хөдөлмөр нэгдлийн мал аж ахуй, цалин хөлсний нягтлан бодогчоор 1991 он хүртэл ажиллав. 1991 -1999 онд Луус сумын Нийгмийн даатгалын байцаагчаар, 1999-2004 онд Луус сумын Тамгын газрын даргаар ажиллаж байгаад 2004-2012 онд орон нутгийн сонгуулиар Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар 2 удаа сонгогдон ажилласан. Д.Сампил 1992 оноос сумын Иргэдийн төлөөлөгчөөр 4 удаа сонгогдон ажилласны дээр, багийн ИНХ-ын даргаар 2 удаа сонгогдон ажилласан байна.

### **ИТХ-ын байгууллагат ажилласан түүхэн дурсамж, онцлог үйл явдлаас**

Тамгын газрын даргаар ажиллах хугацаандаа 2000-2004 онд “ Загвар сум” зорилт дэвшүүлэн хэрэгжүүлж 2005 онд батламжаа гардан авав.

Иргэдийн төлөөлөгчөөр ажиллах хугацаанд нутаг орныхоо хөгжил, ард түмнийхээ аж амьдралыг сайжруулахад анхаарч сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2020 он хүртэлх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг 2009-2010 онд батлан Мерси Кор Олон Улсын байгууллагын дэмжлэгтэй ном хэвлүүлэв.

Хурлын дотоод ажлыг сайжруулах зорилгоор 2004-2008 онд Хурлын байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл, Хурлын хуралдаан, Тэргүүлэгчдийн хуралдааны дэг батлан мөрдөв.

ИТХ-ын төлөөлөгчдийн оролцоотой төсөв санхүү, нийгмийн бодлого, ХАА, байгаль орчны ажлын хэсэг байгуулан хийсэн хяналт шалгалт, өгсөн үүрэг чиглэлийг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн үнэлж дүгнэдэг байв.

Иргэдийн Төлөөлөгчдийн тойргийн байршлаар сумын газрын зураг дээр айл өрх, төлөөлөгчдийн фото зурагтай нь гаргаж сурталчилдаг байсан.

Төлөөлөгчдийг сонгогдсон тойрогт нь ажиллуулж иргэдтэй нь уулзалт зохион байгуулан санал хүсэлтийг нь хүлээн авч шийдвэрлүүлдэг.

ИТХ-аас Хурлын харьяа байгууллага ГХУС салбар зөвлөл, Улаан загалмайн хороо, Эмийн эргэлтийн сан зэрэг байгууллагуудын ажлыг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран иргэдийн дунд төрөл бүрийн хэлбэрийн ажил зохион байгуулдаг. \ Үндсэн хуулийн өдөр, багш нарын баяр, Дэлхийн цусны Донорын өдрөөр Хүндэт донорын алдар тэмдэглэх , эмч нарын өдрөөр Хүйн ээжийн баяр, сумын төвийн эрчүүдийн дунд “Хүмүүний дээд аав-амьдралын түшиг хань” өдөрлөг \

“Сумын хөгжил байгууллагаас эхэлнэ” уриатай байгууллагуудын хэвийн ажиллагааг хангах, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, иргэдэд чирэгдэлгүй үйлчлэх ажлыг сайжруулах зорилгоор Тэргүүлэгчдийн хурлыг

байгууллага дээр нь хуралдуулж тайлан мэдээллийг сонсож үнэлэлт дүгнэлт өгч ажилласан нь бүх байгууллагууд жигд ажиллан харилцан туршлага солилцуулж ажилладаг байв.

Сумын “Гэр бүлийн зөвлөгөөн” “Төрийн албан хаагчдын зөвлөгөөн”, Улаанбаатар хот, аймгийн нутгийн зөвлөл, сумын удирдлага, Иргэдийн төлөөлөгчид оролцсон “Хөрөнгө оруулагчдын уулзалт- зөвлөгөөн” –ийг санаачлан зохион байгуулав.

Иргэдийн төлөөлөгчдийг аймгийн ИТХ, МНУХ-ны сургалтанд хамруулах, Эрээн хот, Дорноговь аймгийн Хамрын хийдээр аялуулах, Өлзийт, Хулд, Луус сумдын ИТХ-ын Төлөөлөгчдийн туршлага солилцох уулзалтыг Цагаан суврагат зохион байгуулсан нь Төлөөлөгчдийн харилцаа, хамтын ажиллагаа сайжирч үзэл бодлоо ойлголцох, хуульд нийцсэн хамтын шийдвэр гаргах, гарсан шийдвэр хэрэгжихэд ихээхэн түлхэц болж байсан.

2013 оноос Наран багийн ИНХ-ын даргаар ажиллаж ИНХ-ын хуралдаанаар “Багийн сан”-гийн журам батлуулан мөрдөж, багийн Засаг даргын үйл ажиллагааны тайлан, ИНХ-ын Тэргүүлэгчдээс хийсэн ажлын тайланг жил бүр тайлагнаж үнэлэлт дүгнэлт өгүүлж ажиллав.

-ИНХ-ыг хөдөөгийн малчдын дунд хуралдуулахын дээр иргэдийн оролцоо, идэвхи санаачлагыг нэмэгдүүлэх зорилгоор жил бүр Цагаан-овоо тахилга зохион байгуулах, “Айргийн баяр-Дуун цэнгүүн”, “Яруу найргийн цэнгүүн” сум байгуулагдсаны 90 жилийн ой угтсан урлагийн үзлэгт багаараа тэргүүн байр эзлэж байв.

- Сум, багийнхаа иргэдийг шагнаж урамшуулах, ажил амжилтыг нь дүгнэж шагналд тодорхойлох ажлыг Тэргүүлэгчдээр хэлэлцэн шийдвэр гаргаж ажиллав. 2004, 2008 онд “Улсын сайн малчин” -аар хоёр малчин шагнагдсан байна.

#### Шагнал:

- Алтан гадас одон, хөдөлмөрийн хүндэт медаль,
- Их Монгол Улс байгуулагдсны 800 жилийн ойн медаль,
- Ардчлалын 20 жилийн ойн медаль,
- НУХ-ны Соёмбо одон,
- МУЗН-ийн нигүүсэл мөнгөн медаль,
- МУЗН-ийн Энэрэл алтан медалийг тус тус хүртсэн.

ИТХ-ЫН АЖЛЫН АЛБА